

## **РАДИО ДАВТАМЖ АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЭРХИЙН БИЧИГ ОЛГОХ, СУНГАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, БИЕЛЭЛТЭНД НЬ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Монгол Улсын Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудыг үндэслэн аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгохдоо ДБЯ-аас батлан гаргасан Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийн дагуу холбооны салбарыг хөгжүүлэх бодлого чиглэл, дэлхийн техникийн хөгжлийн чиг хандлагтай уялдуулан үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх чиглэлийг баримтлана.

1.3. Нийтийн үйлчилгээнд радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл нь хавсралттай байна.

### **Хоёр. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгох**

2.1. Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл авахыг хүссэн аж ахуйн нэгж, байгууллага иргэд нь доорхи бичиг баримтыг бүрдүүлэн Харилцаа Холбооны Зохицуулах Хороонд ирүүлнэ. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргагчийн нэр, харилцах хаяг, утас, факсын дугаар, электрон шуудангийн хаяг, *эрх бүхий байгууллагаас интернэтэд эзэмшил нэртэй болохыг (domain name) тодорхойлсон албан бичиг*, хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах эрхтэйг нотлох гэрчилгээний хуулбар,
- Нэвтрүүлэх гэж буй үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй танилцуулга,
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт (*Тодорхойлолт гэдэгт Харилцаа холбооны тухай хуулийн 7.1.5-д зааснаар харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг дэмжсэн тухай албан ёсны баримт бичиг байна. Засаг даргын тодорхойлолт нь нэг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх бол тухайн сумын; 2 ба түүнээс дээш сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх бол тухайн аймгийн; нийслэлд дүүрэг харгалзахгүйгээр нийслэлийн засаг даргаас Зохицуулах Хороонд ирүүлсэн баримт бичиг байна.*)
- Ашиглахаар сонирхож буй радио давтамж, радио давтамжийн зурвас,
- Радио төхөөрөмжийн байгуулалтын зураглал, газар зүйн байршил, хамрах хүрээний зураглал,

- Антенны байгууламжийн талаархи танилцуулга, ажиллах чиглэл, цагийн хуваарь, азимут
- Нэвтрүүлэх технологи, техникийн дэлгэрэнгүй үзүүлэлтүүд, бүдvvвч зураглал,
- Радио төхөөрөмжийг баталгаажуулж эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ,
- Дамжуулах мэдээллийн аюулгүй байдлыг хангах техникийн нөхцөл,
- Энэхvv журмын хавсралт 1-д заасан өргөдлийн маягтыг бөглөн ирүүлнэ.

2.2. Эрхийн бичиг авах аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь доорхи бичиг баримтыг бүрдvvлэн Харилцаа холбооны зохицуулах хороонд ирvvлнэ. Үүнд:

- Эрхийн зөвшөөрөл авах өргөдөл гаргагчийн нэр, харилцах хаяг, утас, факсын дугаар, цахим шуудангийн хаяг,
- Гэрчилгээний хуулбар(иргэд иргэний үнэмлэхийн хуулбар),
- Ашиглах радио төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, ашиглах давтамж, антенны чиглэл, радио төхөөрөмжийн байгуулалтын зураглал, газар зvйн байршил, хамрах хүрээ, дуудлага, ажиллах цагийн хуваарь,
- Энэхvv журмын хавсралт 1-д заасан өргөдлийн маягтыг бөглөн ирүүлнэ.

2.3. Харилцаа холбооны зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн иж бүрдэл болсон материалыг хvlээн авч, хvсэлт гаргасан радио давтамж нь Үндэсний радио давтамжийн хуваарийн дагуу тусгай хэрэглээний болон нийтийн vйлчилгээ эрхлэхээр хуваарилагдаагvй, өөр этгээдэд ашиглуулахаар олгогдоогvй, тендерээр олгохоор хуваарилагдаагvй, бусад давтамж ашиглагчдад харилцан нөлөөлөл vvcгэхгvй байгаа нөхцөлд уг давтамжийг ашиглаж болох эсэх талаар ХХЗХ-ны Радио давтамж зохицуулалт, хяналтын албанаас санал, дvгнэлт гарган ажлын 21 хоногийн дотор Хорооны хуралдаанд хэлэлцvvлж шийдвэрлvvлнэ. Харин эрхийн бичгийн хувьд тус хорооны даргын шийдвэрээр олгоно.

2.4. Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг нь гэрээний хамт хүчинтэй байна.

2.5. Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн гэрээ, эрхийн бичигт ХХЗХ-ны дарга гарын vсэг зурж, радио давтамж ашиглалт, vйлчилгээний төлбөр хийсний дараа олгоно. Тусгай зөвшөөрөл нь хавсралт 2-т, эрхийн бичиг нь хавсралт 3-д заасан загвартай байна.

2.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь угсралт суурилуулалтын хугацаанд өргөдөлд мэдvvлсэн техникийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулах тохиолдолд ХХЗХ-нд бичгээр мэдэгдэж, зөвшөөрөл авна. Угсралт суурилуулалт дууссаныг мэдэгдсэний дараа ХХЗХ-нд мэдэгдэж зөвшөөрөл авсны дараа ашиглалтанд оруулна. Хэрэв техникийн үзүүлэлтүүдийг ноцтой зөрчсөн, хэрэглэсэн тоног төхөөрөмж нь ашиглалтын зориулалтыг өөрчлөх тохиолдолд зөвшөөрлийг тvдгэлзvvлж, Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөл олгох тухай асуудлыг дахин хэлэлцvvлнэ.

2.7. Радио давтамж ашиглах эрхийн бичгийг өргөдөл гаргагчийн радио давтамж ашиглах хугацааны шаардлагаас vндэслэн vндсэн ба тvр гэсэн төрөлтэй байна. Үндсэн эрхийн бичгийг 2 хvртэл жил, тvр эрхийн бичгийг 3 хvртэл сарын хугацаатайгаар олгож, олгогдсон радио давтамжийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

2.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тусгай зөвшөөрөлд заасан вйл ажиллагаагаа эхлэхгвй бол тусгай зөвшөөрлийг хвчингвй болгоно.

### **Гурав. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн хугацааг сунгах**

3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хугацаа сунгуулах өргөдлөө журмын хавсралт 4-д заасан үнэлгээний хуудсын дагуу бүрдүүлж, зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60 ба түүнээс дээш хоногийн өмнө, эрхийн бичиг эзэмшигч нь эрхийн бичгийн хугацааг сунгуулах тухай хвсэлтийг эрхийн хугацаа дуусахаас 21-ээс доошгвй хоногийн өмнө Харилцаа холбооны зохицуулах хороонд гаргана.

3.2. Радио давтамж, зохицуулалт хяналтын алба нь хугацаа сунгуулах тухай өргөдлийг хвлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор, зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчөөгвй, зохих төлбөр тооцоогоо барагдуулсан эсэхийг хянан вээж, санал дүгнэлтийн хамт Хорооны даргад танилцуулна.

3.3. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны дарга Радио давтамж зохицуулалт, хяналтын албаны санал, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн хугацааг сунгана.

### **Дөрөв. Радио давтамжийн ашиглалт, вйлчилгээний төлбөр**

4.1. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч нь радио давтамжийн ашиглалт, вйлчилгээний төлбөрийг жил бүр төлнө. Дэд бүтцийн сайдын баталсан аргачлалын дагуу уг төлбөрийн хэмжээг тооцоолж гаргана.

4.2. Радио давтамж ашиглалт, вйлчилгээний төлбөрийг тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээ авахын өмнө буюу сунгуулахын өмнө урьдчилан төлсөн байна.

### **Тав. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг шилжүүлэх, өөрчлөлт оруулах**

5.1. Тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрчлөгдөн зохион байгуулагдсан эсхүл хамтарсан хуулийн этгээд байгуулах буюу холбогдох хууль тогтоомжийн дагуу нэгдсэн нь улсын бүртгэлийн гэрчилгээгээр баталгаажсан бол радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.

5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөө бусдад шилжүүлэх тохиолдолд доорхи бичиг баримтыг бүрдүүлэн Харилцаа холбооны зохицуулах хороонд өгнө. Үүнд:

- Тусгай зөвшөөрлөө шилжүүлэх болсон шалтгаан, тайлбар үндэслэлийг нотолсон шилжүүлэх шийдвэр гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр (нотариатаар баталгаажуулсан байх);
- Тусгай зөвшөөрлөө шилжүүлэх тухай хүсэлт гаргасан албан бичиг;
- Тусгай зөвшөөрөл шилжүүлж авах байгууллагын албан бичиг;
- Шилжүүлж авах байгууллагын нэр, харилцах хаяг, утас, факсын дугаар, хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах эрхтэйг нотлох гэрчилгээний хуулбар.

5.4. Харилцаа холбооны зохицуулах хороо нь шилжүүлэх тухай бүрдүүлсэн бичиг баримтыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хянан үзэж, зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн эсэхийг хянан үзэж, Хорооны хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

5.5. Эрхийн бичиг эзэмшигч нь эрхийн бичгээ бусдад шилжүүлэх тохиолдолд доорхи бичиг баримтыг бүрдүүлэн Харилцаа холбооны зохицуулах хороонд өгнө. Үүнд:

- Эрхийн бичгээ шилжүүлэх тухай албан бичиг,
- Эрхийн бичиг шилжиж очих байгууллагын албан бичиг,
- Шилжүүлж авах байгууллагын гэрчилгээний хуулбар (иргэд иргэний үнэмлэхийн хуулбар),
- Энэхүү журмын хавсралт 1-д заасан өргөдлийн маягтыг бөглөн ирүүлнэ.

5.6. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны дарга Радио давтамж зохицуулалт, хяналтын албаны санал, дүгнэлтийг үндэслэн эрхийн бичгийг шилжүүлнэ.

5.7. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч хүсэлт гаргасан доорхи тохиолдолд өөрчлөлт оруулна. Үүнд:

- Нэвтрүүлэгч болон антенны хүчин чадлыг нэмэгдүүлэх, багасгах;
- Тоо ширхэгт өөрчлөлт орсон;
- Эрхийн бичигт заасан ашиглах тоног төхөөрөмжийг шинээр худалдан авсан;
- Давтамжийн сувагт харилцан нөлөөлөл орсон зайлшгүй өөрчлөх дүгнэлт мэргэжлийн байгууллагаас гарсан;
- Нэвтрүүлэгчийн байршлыг өөрчлөх;
- Ажиллах цагийг нэмэгдүүлэх, багасгах.

5.8. Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Радио давтамж, зохицуулалт хяналтын албаны санал, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл, эрхийн бичигт өөрчлөлт оруулах шийдвэр гаргана.

### **Зургаа. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг түдгэлзүүлэх, цуцлах**

6.1. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн нөхцөл, шаардлагыг биелүүлээггүй, бусад хэрэглэгчдийн хэвийн ажиллагаанд хохирол учруулсан, төлбөр тооцоогоо барагдуулаагүй тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

6.2. Түдгэлзүүлэхээр тогтоосон хугацаанд өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлсэн бол түдгэлзүүлсэн эрхийг Зохицуулах хорооны даргын шийдвэрээр сэргээж, энэ тухай тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэнэ.

6.3. Тусгай зөвшөөрлийг дараахь тохиолдолд Хорооны хуралдаанаас хвчингвй болгосон шийдвэр гаргана. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хвсэлт гаргасан;
- Хуулийн этгээд татан буугдсан;
- Тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- Тусгай зөвшөөрлийн болон техникийн нөхцөл шаардлагыг удаа дараа зөрчсөн;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь вйл ажиллагаа эрхлэх боломжвй болсон;
- Радио давтамжийн ашиглалт, в йлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгвй;
- Тусгай хэрэглээний ангилалд ашиглаж байгаа радио давтамжийн зурвасыг санаатайгаар ашигласан, шуугиан үвсгэсэн буюу сонссон;
- Тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгвй;
- Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгвй;
- Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан ба эзэмшигч сунгуулах хүсэлт гаргаагвй;
- Эрхийн бичгийн хугацаа дууссан.

6.4. Эрхийн бичгийг дараахь тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга хвчингвй болгосон шийдвэр гаргана. Үүнд:

- Эзэмшигч хвсэлт гаргасан;
- Хуулийн этгээд татан буугдсан;
- Эрхийн бичигт заасан радио давтамжийг дур мэдэн өөрчилсөн, нөхцөл шаардлагыг удаа дараа зөрчсөн;
- Төлбөрөө хугацаанд нь төлөөгвй;
- Гэрээнд заасан үүргээ зөрчсөн.

6.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн Харилцаа холбооны нийтийн вйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нь хвчингвй болсон тохиолдолд радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг хвчингвйд тооцно.

6.6. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг хвчингвй болгосон тухай шийдвэрийн талаар Харилцаа холбооны зохицуулах хорооноос шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчид бичгээр мэдэгдэж нийтэд зарлана.

### **Долоо. Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгохоос татгалзах**

7.1. Хвссэн радио давтамж болон зурваст ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгохоос дараахь тохиолдолд татгалзана. Үүнд:

- Тусгай хэрэглээний ангилалд орсон;
- Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгээр ашиглагдаж байгаа;
- Бусад төрлийн радио давтамжийн вйлчлэх хврээтэй давхцаж байгаа;
- Бусад төрлийн радио төхөөрөмжинд харилцан нөлөөлөл үвсгэх тохиолдолд.

## Найм. Бусад

8.1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь Улсын нэгдсэн бүртгэлийг радио давтамжийн ангилал, зориулалт, ашиглагчийн нэр, хаяг, ашиглахаар зөвшөөрөгдсөн радио давтамж, давтамжийн зурвас, үйлчлэх хүрээ, газар зүйн байршил, ажиллах хугацаа, хвчин чадал зэрэг үзүүлэлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр хөтөлнө.

8.2. Радио давтамж ашиглалт үйлчилгээний төлбөр тооцооны асуудлыг Харилцаа холбооны зохицуулах хороо хариуцан гүйцэтгэнэ.

8.3. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгохтой холбогдох бvх материал Харилцаа холбооны зохицуулах хороонд бичиг хэргийн журмын дагуу хадгалагдана.

8.4. Энэхvв журмаар зохицуулагдаагvй харилцааг тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

*/Энэ журамд 2003 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 39, 2004 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 36, 2007 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 23, 2009 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 58 дугаар тогтоолоор орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тус тус тусгасан болно./*

----- о О о -----